

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2007 оны 10 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 156

Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий
этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний
хөлсийг шинэчлэн тогтоох тухай

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийн 6.1.5 дахь заалт, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г хавсралт ёсоор шинэчлэн баталж, 2007 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдсүгэй.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг шинэчлэн тогтоох тухай” 29 дүгээр тогтоолыг 2007 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болгосугай.

3. Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дор дурдсан хуваарийн дагуу төвлөрүүлж байхаар тогтсугай:

- 1) Үнэт цаасны арилжааны гүйлгээнээс олсон шимтгэлийн орлогоос Хороонд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг арилжаа явагдсан өдөр бүр тооцож үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй мэргэжлийн байгууллага дахь Хорооны дансанд;
- 2) Жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тухайн оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор Төрийн сан банк дахь тус хорооны 9000250001 тоот дансанд;
- 3) Үйлчилгээ үзүүлсэн тухай бүр нэг удаа авах үйлчилгээний хөлсийг тухай бүр Төрийн сан банк дахь тус Хорооны 900025001 тоот дансанд.

4. Энэхүү тогтоолтой нийцүүлэн холбогдох дүрэм, журам, төлбөр тооцооны програмд оруулбал зохих өөрчлөлтийг ажлын 5 хоногт багтаан оруулж, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоол батлагдсан өдрөөс эхлэн Хорооны дансанд төвлөрүүлж ажиллахыг үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудын удирдлагад үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

/ Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 98 дугаар, 2011 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 72 дугаар, 2013 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 40 дүгээр, 2013 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 73 дугаар тогтоолоор орсон нэмэлт өөрчлөлтийг оруулав/

Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ /төгрөгөөр/

№	ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ		ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС		
	ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСӨД ХАМААРАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ	ЭРХЭЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА	АРИЛЖАА, ГҮЙЛГЭЭ ХИЙГДСЭН ӨДӨР ТУТАМ /хувиар/	ТУХАЙН ЖИЛ БҮР /төгрөгөөр/	ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН ТУХАЙ БҮР /төгрөгөөр/
1	1.1 Арилжаа эрхлэх 1.2 Төлбөр тооцоо /биржийн ¹ / 1.3 Брокер 1.4 Дилер	1. а/ Хувьцаа 1. б/ Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын бонд 1. в/ Компанийн бонд	Үнэт цаасны арилжааны гүйлгээнээс тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагын олсон шимтгэлийн орлогын 10 хувь 1.а/ Хувьцааны арилжааны худалдах, худалдан авах хэлцэл тус бүрийн үнийн дүнгийн 0,04 хувь; 1.б/ Хувьцаанаас бусад үнэт цаасны арилжааны гүйлгээнээс олсон шимтгэлийн орлогын 10 хувь.	- -	- -
/Энэ хэсгийг СЗХ-ны 2013 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан./					
/Энэ хэсгийг СЗХ-ны 2013 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 73 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан./					

¹ Үнэт цаасны төлбөр тооцоо эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс авах зохицуулалт үйлчилгээний хөлсний хийт хэмжээ нь биржийн арилжаа болон биржийн бус гүйлгээний нийлбэрээр тодорхойлогдоно.

2	Төлбөр тооцоо /биржийн бус/	2.1.1. өөрийн эхнэр, эсхүл нөхөр, өөрийн болон эхнэр, эсхүл нөхрийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, авга, нагац, ах, эгч, дүү, төрүүлсэн болон үрчилж эсхүл нөхрийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, авга, нагац, ах, эгч, дүү, төрүүлсэн болон үрчилж авсан хүүхэд, ач зээ, тэдгээрийн хүүхэд зэрэг төрөл, садангийн хүнээс гадна, хүргэн бэрд үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бэлэглэсэн гүйлгээг гүйцэтгэх үйлчилгээ	2.1.1. Үйлчилгээ үзүүлсний төлөө үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн 20 хувь	-	-
		2.1.2. Энэхүү хавсралтын 2.1.1-д зааснаас бусад иргэн, хуулийн этгээдийн хооронд хийгдсэн үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бэлэглэхтэй холбоотой гүйлгээг гүйцэтгэх үйлчилгээ 2.2. Өвлүүлэх гүйлгээг гүйцэтгэх үйлчилгээ 2.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх үйлчилгээ 2.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлээс бусад журмаар үүргийн гүйцэтгэл хангах 2.5.Бусад гүйлгээ	2.1.2. Үйлчилгээ үзүүлсний төлөө үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн 20 хувь 2.2. Үйлчилгээ үзүүлсний төлөө үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн 20 хувь 2.3. Үйлчилгээ үзүүлсний төлөө үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн 20 хувь 2.4. Үйлчилгээ үзүүлсний төлөө үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн 20 хувь 2.5. Үйлчилгээ үзүүлсний төлөө үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагын үйлчлүүлэгчдээс авсан шимтгэлийн 10 хувь	-	-
3	Андеррайтер	Андеррайтерын үйл ажиллагаа		2 000 000	
4	Хамтын хөрөнгө оруулалтын байгууллага буюу хөрөнгө оруулалтын сан	Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа	-	1 500 000	-
5	Хөрөнгө оруулалтын менежмент	Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа	-	500 000	-
6	Хөрөнгө оруулалтын зөвлөх	Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа	-	300 000	-
7	Үнэт цаасны зах	7.1 Андеррайтер	-	-	200 000

	зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах	7.2 Брокер 7.3 Дилер 7.4 Үнэт цаасны арилжаа эрхлэх 7.5 Үнэт цаасны төлбөр, тооцоо 7.6 Үнэт цаасны хадгаламж 7.7 Хөрөнгө оруулалтын сан 7.8 Хөрөнгө оруулалтын менежмент 7.9 Хөрөнгө оруулалтын зөвлөх	- - - - - - - - -	- - - - - - - - -	100 000 150 000 200 000 200 000 200 000 200 000 60 000 100 000
<i>/Энэ хэсгийг СЗХ-ны 2011 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 72 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан./</i>					
8	Салбар байгуулах зөвшөөрөл 7.1. Хот /Улаанбаатар, Эрдэнэт, Дархан/ 7.2. Хөдөө		- -	- -	100 000 20 000
9	Оноосон нэр өөрчлөх		-	-	2 000 000
10	Тендер санал зарлах		-	-	200 000
11	Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах /Компани өөрчлөн байгуулах /ХХК болон хэлбэрээ өөрчлөх, нэгдэх, нийлэх, тусгаарлах, хуваах/ болон үнэт цаас нэмж гаргах, хувьцаа хуваах, нэгтгэх		-	-	200 000
12	Шинээр үнэт цаас бүртгүүлэх		-	-	
13	Мэргэжилтнийг аттестатчлахад		-	-	50 000
14	Үрэгдүүлсэн, гэмтээсэн гэрчилгээг нөхөж олгох		-	-	200 000

15	Баримт бичиг хуулбарлан өгөх		-	-	1 000 /нүүр тус бүрээс/
16	Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох	Зэрэглэл тогтоох үйл ажиллагаа	-	-	3 000 000
/Энэ хүснэгтийн 16 дугаар мөрийг Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 98 дугаар тогтоолоор нэмсэн/					
		17.1 Мэргэжлийн оролцогч байгууллагын тусгай зөвшөөрлийг сэргээх	-	-	500 000
		17.2 Мэргэжлийн оролцогч байгууллагын гүйцэтгэх захирлыг томилохыг зөвшөөрөх	-	-	50 000
		17.3 Дүрмийн сангийн бүтэц, хэмжээ, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг бүртгэх	-	-	100 000